

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ТУШААЛД
ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЖ БАЙНА.**

Нэг. Сонгон шалгаруулалтын зорилго

Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын Тамгын газрын даргын сул орон тоог төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, тус газарт ажиллаж байгаа албан хаагчдаас шалгаруулна.

Хоёр. Сонгон шалгаруулалтын бүртгэл

Зарлаж буй сул орон тоонд **боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тус газарт ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын материалыг төв байрны 203 "Б" тоот өрөөнд ажлын хэсэг **2016 оны 11 дүгээр сарын 23- 24-ны өдрүүдэд 09.30-11.30, 15.00-16.30** цагийн хооронд, **11 дүгээр сарын 25-ны өдөр 09.30-11.30** цагийн хооронд хүлээн авна.

Гурав. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн албан хаагчид дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
2. Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
3. Монгол Улсын иргэний үнэмлэх; /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
4. Ажилласан жилийг тооцох Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны хуулбар, эх хувийн хамт. /ажилласан жилийг тооцох тул хөдөлмөрийн үйл ажиллагаагаа хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн он, сар, өдрөөр нь нарийвчлан бичиж бэлтгэж ирэх/
5. Төрийн албан хаагчийн тангараг өргөсөн хуудас
6. Тухайн албан тушаалд томилогдсон тушаалын хуулбар
7. Сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээний илтгэх хуудас

**ТАМГЫН ГАЗАР
2016.11.21**

В.ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын магистрын зэрэгтэй	Дээд боловсролын бакалаврын зэрэгтэй
		Мэргэжил	Эдийн засагч, эрх зүйч, бизнесийн удирдлага, орчуулагч	Техникийн болон Нийгмийн ухааны мэргэжилтэй
		Мэргэшил	"Бизнесийн удирдлага", "Стандартчилал, Тохирлын үнэлгээ, Удирдлагын тогтолцооны аудитор, шинжээч	"Стандартчилал, Тохирлын үнэлгээний талаар мэргэшсэн байх
		Туршлага	Салбартаа ажилласан туршлагатай. Удирдах албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан
		Ур чадвар	Удирдан зохион байгуулах, өөрчлөлтийг манлайлах, бодлогын баримт бичиг боловсруулах чадвартай, Компьютерийн өргөн хэрэглээний программуудыг эзэмшсэн, 2-оос доошгүй гадаад хэлний мэдлэгтэй байх, Монгол хэлний найруулга зүй, нэр томъёо, хэллэг төгс эзэмшсэн байх,	Хамт олныг удирдан шинэчлэлтийг манлайлах, үр дүнд чиглэн ажиллах, бизнес сэтгэлгээтэй байх
	1.2 Тусгай шаардлага	- Хууль тогтоомжийг сахих, мөрдөх, өндөр ёс суртахуунтай байх; - Манлайлах, удирдан зохион байгуулах; - Илтгэх, оновчтой шийдвэр гаргах; - Нууцыг хадгалах; - Ажлын ачаалал даах окуны болон бие бялдрын чадавхитай байх.		